# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 12-ны өдөр Дугаар БА-019/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол улсын нийслэлийн Багануур дүүргийн 2 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын хагас зоорьтой, 2 давхар, 100 (нэг зуу) ортой цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дүгээр захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 06 сарын 05-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2019.11.20 огноо, 005708 дугаар, 715/2019

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: ЭКЖ-2019/24

2.3. Боловсролын яам оноосон нэр, 9069001077 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9116621 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, III байр, 266282 холбоо барих утас,

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Динатос ХХК оноосон нэр, 1611008067 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5667305 регистрийн дугаар, БУ43-1575/17 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Ховд аймаг, Жаргалант сум, 2-р баг, Баатархайрхан, 11,33 тоот 99223262 холбоо барих утас, Dinatoshhk@gmail.com цахим шуудангийн хаяг,

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: Хаш Дайчин ХХК оноосон нэр, 1611011562 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 4094301 регистрийн дугаар, БУ43-746/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Ховд аймаг, Жаргалант сум, 6-р баг, Жаргалан, 2/30 тоот 99434466 холбоо барих утас, цахим шуудангийн хаяг,

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Энхийн жаргал констракшн ХХК оноосон нэр, 9011682020 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6197833 регистрийн дугаар, ЗТ11-751/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6-р хороо, 10-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө, 26,2 тоот 99054272 холбоо барих утас, цахим шуудангийн хаяг,

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:

Боловсролын яам оноосон нэр, 9069001077 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9116621 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, III байр, 266282 холбоо барих утас,

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

√ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

ХЯНАЛТ Ц
ГА
Барилга байгуул
оруул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ дунд төвөгшилтэй ангиллын хагас зоорьтой, 2 давхар, 100 (нэг зуу) ортой цэцэрлэгийн зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:
Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:
   а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;
   б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

   а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

   б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 7 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 28 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох 1 хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Дунд төвөгшилтэй ангиллын хагас зоорьтой, 2 давхар, 100 (нэг зуу) ортой цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Багануур дүүргийн 2 дугаар хороо, Боловсролын яамны захиалгатай, хагас зоорьтой, 2 давхар, 100 (нэг зуу) ортой цэцэрлэгийн барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга: Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын Барилга, байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер (Т.Амардалай)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.
Объектын дугаар: 631
Огноо: 2025 он 01 сар 22 өдөр
Бүртгэсэн: О. Жигр
УЛААНБААТАР ХОТ ТТМ 1584

# БАГАНУУР ДҮҮРГИЙН 2 ДУГААР ХОРОО, БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ЗАХИАЛГАТАЙ, ХАГАС ЗООРЬТОЙ 2 ДАВХАР, 100 ОРТОЙ ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 06 дугаар сарын 05 Улаанбаатар хот

Багануур дүүргийн 2 дугаар хороо, Боловсролын яамны захиалагатай, хагас зоорьтой, 2 давхар 100 ортой цэцэрлэгийн зориулалттай барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдааг тус барилгын 1 давхарт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр 11 цагт 14 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж 13 цагт дуусав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

Хуралд:

| | | |
|---|---|---|
| 1. | Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга | О.Оджаргал |
| 2. | Комиссын нарийн бичгийн дарга: Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ийн Барилга, байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер | Т.Амардалай |
| 3. | Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Б.Батбаатар |
| 4. | Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт, Хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 5. | Нийслэлийн онцгой байдлын газар, Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа | Ж.Хүдэрчулуун |
| 6. | Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах, норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн | О.Ундрах |
| 7. | Багануур Цахилгаан түгээх сүлжээ салбар, ашиглалт засварын инженер | Х.Сүхболд |
| 8. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, ХУДХБНХ | Ч.Уранчимэг |
| 9. | Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын архивч | Б.Оюунжаргал |
| 10. | Мэдээлэл холбоо сүлжээ ХХК багануур дүүргийн кабель шугамын инженер | Б.Наранбаатар |
| 11. | Зураг төсөв зохиогч, Энхийн жаргал констракшн ХХК Ерөнхий инженер | Ш.Энхболд |
| 12. | Ашиглалт хариуцсан байгууллага, 288-р цэцэрлэгийн эрхлэгч | Д.Энхмаа |
| 13. | Багануур-Ус ААТҮГ Ерөнхий инженер | Ж.Мөнхцэцэг |
| 14. | Гүйцэтгэгч “Динатос” ХХК-ийн Захирал | Ц.Баяржаргал |

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 14
- Хүрэлцэн ирсэн -14
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 14

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Багануур дүүргийн 2 дугаар хороо, Боловсролын яамны захиалагатай, хагас зоорьтой 2 давхар, 100 ортой цэцэрлэгийн зориулалттай барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, Аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Г.Батбаатар**

- Гадна тохижилтын ажлыг зураг төслийн дагуу хийж дуусгах,
- Дээврийн ажлын ил далд ажлын актыг үзүүлэх хар цаасыг дээш өргөж норм дүрмийн дагуу хийх,
- Гүйцэтгэгч зураг төсөл зохиогчийн тусгай зөвшөөрлийг үзүүлэх,
- Арматурын шинжилгээ үзүүлэх,
- Зоорийн давхарт орох хэсэгт хаалт хийх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв**

- Зурагт заасны дагуу нөөц /усны/ савыг байрлуулан ашиглалтын хэвийн нөхцөлийг хангуулах,
- бохирын цооногын таг солих,
- Нам даралтын зуухыг бүртгэлд хамруулан /НХШГ/ пасспортцуулах,
- Зуухны тоног төхөөрөмжийн хэмжих хянах хэрэгслийг баталгаажуулах,
- Нам даралтны зуухны аюулгүй ажиллагааны зааюарчилгааг зуухны өрөөнд байрлуулах, ашиглалтын талаар хангагч байгууллагад сургалт өгч хүлээлгэн өгөх,
- Зуухны өрөөг засварлан шинэчлэх, галч нарын /зуухны/ өрөөг норм, стандартад нийцүүлэн тохижуулах, тоног төхөөрөмжийн хаягжуулалт хийх,
- Цэвэр усны шинжилгээнд өгөх, нөөцийн савыг пасспорт шалгуулах,
- Гадна дотор цэвэр бохир усны худагт шат, таг хийх,
- Агаар сэлгэлтийн ердийн системийн шахтыг өндөрлөх,
- Зуухны яндang нормын дагуу угсрах /өндөрлөх малгай хийх/,
- Зургын дагуу 1-р давхрын шалны халаалт хийх, Актаар баталгаажуулах,
- Гадна цэвэр бохир, дулаан хангамжийн гадна зураг төсөл шалгуулах,
- Үнс хадгалах сав хийх,
- Худгын өрөөг засварлаж удирдлагын самбар хийх,
- Үүрэг даалгаврын биелэлтийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх.

Барі

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Барилга, байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер **Т.Амардалай**

- Төсөв зурагт тусгагдсан ногоон байгууламжийн ажлыг дуусгах,
- Цонхны амалгаануудыг засах, гүйцээх,
- Бороонны усны хаялага зураг төслийн дагуу хийх засах, гүйцээх,
- Халаатын тогооны барилгын дотор заслын ажил дутуу хийх,
- Шалны халаалтыг зургын дагуу хийх,
- Дээврийн агааржуулалтын шахтны өндрийг парпетнээс дээш гаргах.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах, норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн **О.Ундрах**

- Дээврийн хар цаасыг парпедруу бүтэн өгсгөж парпетны төмрийг хийх,
- Агааржуулалтын шахтны дээр зориулалтын төмөр малгай хийх,
- Хулдаасан шал болон чулуун шалны уулзвар хэсгүүдэд ам дарагч хийх,
- Бүлгүүдийн шалны түвшин ариун цэврийн өрөөний шалны түвшингийн зөрүүг засаж аюулгүй болгох,
- БТХуулийн 5.7.1-д заасны дагуу НСШ төлөх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Нийслэлийн онцгой байдлын газар, Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа **Ж.Хүдэрчулуун**

- КТПН-доторх өвс шарилж цэвэрлэж, хайрга дэвсэж анхааруулга байрлуулах,
- БНбД 21.01.02-н 6.29 дэх заалт зөрчигдсөн галын аврах шатны өргөнг 1.35-р төлөвлөх байсан боловч 80см-р хийсэн,
- Аврах шатны хашлага бариул дутуу хийсэн ба анги бүрээс гарах аврах гарцанд довжоо төлөвлөхгүй шууд гарахад саадгүйгээр төлөвлөх,
- ГДУХС-н хайрцагны өнцөг булан бүрт хамгаалалт зөөлөвч хийх,
- Дээврийн ус зайлуулах хоолой стандарт бус тавигдсан зоорийн давхарт ус орох нөхцөл бүрдсэн,
- Зураг хянасан дүгнэлтэнд заагдсан гадна гидрант төлөвлөөгүй, БНбД 21.02.02-н 5.17 дахь заалтын зөрчиж галын аврах шатны амрах тавцанг лист төмрөөр төлөвлөсөнг солих,
- БНбД 21.04.05-н 12 дахь заалтын дагуу төлөвлөсөн галын дохиоллын системыг шалгаж акт үйлдэх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага **Ч.Уранчимэг**-

- Налуу замын эхлэл төгсгөлийг засаж янзлах /халитрахгүй болгох/,
- Хаалганы босгыг нам болгох,

ХЯНАЛ
лга байг
ор

- Ариун цэврийн 00 өрөөнд зориулалтын стандартын тусгай тоноглол бариул хийх,
- Ариун цэврийн 00 өрөөны босгыг нам болгох.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Багануур ЦТС-ын Салбарын ашиглалт засварын инженер **Х.Сүхболд**

- КТПН дээр төмөр хийц будах,
- КТПН-ний шуурхай ажиллагааны нэр хаяг хийх, схем батлуулах,
- 6/04кВ КТПН-ний газардуулга будах,
- КТПН-ний 6кВ талд ачаалал таслагч тавих /техникийн нөхцөлийн дагуу/,
- КТПН-ий 0,4кВ талд болон кабелд зориулалтын материалаар бирк хийх,
- Дэд өртөөний талд 0,4кВ талд цэнэг шавхагч суурилуулах,
- КТПН-ий хашаанд плакат хийх,
- 6/0,4кВ КТПН болон 6 кВ-н АШ-н хамгаалалт зурвасыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүүргийн газрын албаны мэдээллийн санд оруулах албан бичгээр баталгаажуулах,
- 6кВ-н АШ-д оврын тэмдгийг зориулалтын тэмдгээр солих,
- 6кВ-н агаарын шугамд давтан газардуулга хийх,
- БЦТСС-р хэмжилт хийлгэх гүйцэтгэлд протокол хавсаргах,
- 6кВ-н АШ-н гэмтэл заагчыг салбар АШ-ны эхний хуурай салгууртай тулгуурт хийх /шилжүүлэх/,
- Халаалтын байрны газардуулгыг хийх, шитны бичиглэл кабелын биркийг хийх,
- Барилгын газардуулга хийх, хэмжилт хийлгэх,
- 0,4кВ-н байрны шитэнд ухаалаг сүлжээнд ажиллах зориулалтын тоолуур суурилуулах,
- Барилгын дотор шитэнд дифферинциал автомат суурилуулах,
- Гадна цахилгаан хангамжийг мэргэжлийн ашиглагч байгууллагын хөрөнгөд бүртгүүлэх, хүлээлгэж өгөх,
- 6кВ-н АШ-н зам давуулгын оврын хэмжээг норм, дүрэмд бариулах,
- Хуурай салгуурт цоож хийх,
- Дэд өртөөнд цоож хийх,

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын Архивын архивч **Б.Оюунжаргал**-

- Архивд баримтаа бүрдүүлэн нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй өгөх,
- Ажлын зургийг зургийн бүрдлийн дагуу бүрэн бүрдэлтэй эх хувиар өгөх,
- Хувийн хэрэгт нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй эх хувиар өгөх /Нүүр хуудас хийх, дотоод товьеог хийх, хуудас зөв дугаарлах/
- Төсөв тусад нь эх хувиар хэрэг бүрдүүлж өгөх,
- Ашиглагч байгууллагад ажил хүлээлцэ акт үйлдэн хувийн хэрэгт өгөх, /Хувийн хэрэгт орох бүрдлийн эх хувьд анхаарах/,
- Барилгад хэрэглэсэн бараа материалын сертификат, чанарын гэрчилгээ, лабораторын шинжилгээний дүнг хавтаслан хэрэг бүрдүүлэх,

Т ШАЛГА
ГАЗАР
уламжийг
улах коми

Ашиглагч байгууллага 288-р цэцэрлэгийн эрхлэгч **Д.Энхмаа**

- Хар шороо асгаж зүлэгний үр цацах,
- Паарны хаалтыг гүйцээх,
- Ус зайлуулах хоолойн битүүлсэн нүхийг замаск эмульс хийх,
- Уурын зуухны барилгын хаалганы амалгаа дотор цэвэрлэгээ хийх,
- Гүний худагны дотор засал хийж цэвэрлэх,
- Цооногийн малгайвч хийх /үнэр гаргагч яндангийн/

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Зураг төсөв зохиогч Энхийн жаргал констракшн ХХК Ерөнхий инженер **Ш.Энхболд**

- Цэцэрлэгийн барилгын 1-р давхрын ангиудад зураг төсөл болон МУ-н хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа БНбД-д заасны дагуу шалны халаалтыг хийж гүйцэтгэх,
- Гадна зам талбай ХБИ-д зориулагдсан хөтөч зам болон эхлэл төгсгөл эргэлтийн холбогдох стандартад заасны дагуу хийх гүйцэтгэх,
- Барилгын дотор засал хийгдэх явцад гарсан бохирдолыг сайтар цэвэрлэх,
- Хагарсан цонхны шилийг бүрэн солих,
- Цоклын гадна өнгөлгөөний хагарч бутарсан чулууг буулгаж шинээр сольж хийх,
- Аваарын гарцын металл шатыг гүйцээж суурийн бэхэлгээг сайн хийх, 1,2-р давхрын өрөөний ариун цэврийн өрөөрүү орох шалны түвшинг чөлөөтэй орж гарах боломжтой болгох,
- Гадна аваарын металл шатны дээрээс буусан усны хаялагыг зөөж засварлах,
- Дээврийн парпедрүү дээш өгсүүлж хийсэн хар цаасны амыг зураг төсөлд тусгасны дагуу хийж гүйцэтгэх,
- Узельрүү орох шатны дээд хэсэгт өнгө ижил чулуу өнгөлгөөгөөрт бүрж засварлах,
- Бүлгийн өрөөнүүдийн ридиаторын хаалтын эвдэрсэн хэсгийг солих,
- Дээвэрлүү гарах шахтны өрлөгийн нэмж хийх,
- Зураг төсөлд тусгагдсан гадна тохижилтын дагуу ажлуудыг хийж гүйцэтгэх,

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Багануур-Ус ААТҮГ Ерөнхий инженер **Ж.Мөнхцэцэг**

- Усны шинжилгээ өгөх, гүний худагт усны тоолуур суурилуулах
- Гадна шугамын дулаалгыг гүйцээж хийх, зориулалтын ороох материал ороох, шат хийх
- Зуухны ажиллахгүй байгаа хэмжих хэрэгслүүдийг солих
- Зуухны ашиглалтын заавар, зарчмын схемийг зурж байрлуулах, хаалтын тэмдэглэгээ хийх
- Узелийн өрөөнд агааржуулалт хийх, шугам хоолойн дулаалга сайжруулах, засвар хийх
- Гадна худаг камерийн таг, бохир соруулах цооногийн тагийг зориулалтын тагтай болгох

- Гүний худгийн насосны ашиглалтын заавар өгөх, техникийн тодорхойлолт өгөх
- Шугам хоолойн гарал үүслийн гэрчилгээ сертификат үзүүлэх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК багануур дүүргийн кабель шугамын инженер- **Б.Наранбаатар**

- Барилга төсөвд суугдаж хөрөнгө зардал суугдаагүй учир хийгдэх боломжгүй.

Гүйцэтгэгч Динатос ХХК-ийн захирал **Ц.Баяржаргал**

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал**

- БНбД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт гаргах,
- БТХ-н дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх,
- Батлагдсан ЗТ-ийн дагуу 89 ширхэг мод, 25 х, 48,6м урт бутлаг ургамал тарих.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Багануур дүүргийн 2 дугаар хороо, Боловсролын яамны захиалагатай, хагас зоорьтой, 2 давхар, 100 ортой цэцэрлэгийн зориулалттай барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

9024041846
8314551 СБТ24866

Тэмдэглэл хөтөлсөн:
Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын
Барилга, байгууламжийн захиалагчийн
хяналтын хэлтсийн Хяналтын инженер (Т.Амардалай)